



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY

“ГЕОДЕЗИ” УЛСЫН ОЛИМПИАД

2024

Хэзээ: 2024 оны 04-р сарын 20-ны 8:30 цагт

Хаана: ШУТИС-ийн төв байр “Олон улсын эрдэм шинжилгээний хурлын танхим” VIII-12 давхарт

Зохион байгуулагч:

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, Уул уурхайн сургууль
Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Ерөнхий Газар
Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Холбоо
ШУТИС-ийг 2001 оны Геодези, Сансрын геодези хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид
Доктор А.Дамдинсүрэнгийн гэр бүл, үр хүүхэд

Хамрах хүрээ:

Олимпиадад “Геодези” хөтөлбөрөөр суралцдаг, сургалтын хөтөлбөрт нь геодезийн хичээлүүд багтсан их, дээд сургууль, коллежийн оюутнууд оролцох боломжтой.

Мэдүүлэг хүлээж авах хугацаа: 2024.04.20

Мэдүүлэг хүлээн авах байр: ШУТИС-ийн хичээлийн 1-р байр

Хэвлэмэл хэлбэрээр: 1-227 тоот өрөө **Цахим хэлбэрээр:** blgnsrn@must.edu.mn

Холбоо барих утас: 99141733

БАТЛАВ. ГУУС-ИЙН ЗАХИРАЛ

К.ХАВАЛБОЛОТ



**А.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ “ГЕОДЕЗИ-2024” УЛСЫН
ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“ГЕОДЕЗИ” улсын олимпиадыг 2016 онд ШУТИС-ийн ГУУС-ийн Геодезийн салбар санаачлан, жил бүр амжилттай зохион байгуулж ирсэн. Тус олимпиадад “Геодези” хөтөлбөрөөр суралцдаг, геодезийн шинжлэх ухааныг судалдаг их, дээд сургууль, коллежийн оюутнууд оролцох бөгөөд 2024 оноос ШУТИС-ийн хүндэт профессор, доктор А.Дамдинсүрэнгийн нэрэмжит болгон зохион байгуулж байна.

2024 онд тус олимпиадыг дараах байгууллагууд ивээн тэтгэж, хамтран зохион байгуулж байна. Үүнд:

- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, Уул уурхайн сургууль (ШУТИС-ийн ГУУС)
- Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Ерөнхий Газар (ГЗБГЗЗЕГ)
- Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Холбоо (МГФЗЗХ)
- ШУТИС-ийг 2001 оны Геодези, Сансрын геодези хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид
- Доктор А.Дамдинсүрэнгийн гэр бүл, үр хүүхэд

“ГЕОДЕЗИ-2024” улсын олимпиад 2024 оны 04-р сарын 20-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн VIII байрны 12 дугаар давхрын уулзалтын танхимд болно.

ХОЁР. ОЛИМПИАДЫН ЗОРИЛГО

Геодезийн шинжлэх ухааны онол, арга зүй, сургалтын болон практик үйл ажиллагааны хүрээнд суралцаж буй оюутнуудын эзэмшсэн онолын мэдлэгийг бататгаж, практик дадал чадварыг хөгжүүлэхэд олимпиадын зорилго оршино.

ГУРАВ. ОЛИМПИАДЫН ЗОРИЛТ

1. Геодези мэргэжлийг сурталчлах;
2. Оюутнуудын геодезийн хичээлээр үзсэн онол, практикийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, бие дааж хэмжилт, зураглал, боловсруулалт хийх чадварыг сайжруулах;
3. Оюутан залуусын чөлөөт цагийг зөв боловсон үр дүнтэй өнгөрүүлэх, сурах идэвхи сонирхлыг нэмэгдүүлэх, туршлага солилцох;
4. Оюутнуудын өрсөлдөх, илтгэл тавих, өөрийгөө хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, бие даасан бүтээлч ажиллагаанд сургах;
5. Геодезийн салбарт нэвтэрч байгаа шинжлэх ухааны нээлт, техник, технологийн шинэчлэлийн талаар мэдлэг, мэдээлэл солилцох;
6. Их, дээд сургуулиудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог өргөжүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг дэмжих;

ДӨРӨВ. “ГЕОДЕЗИ 2024” УЛСЫН ОЛИМПИАДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Олимпиад нь геодезийн хичээл судалдаг бүх их, дээд сургууль, коллежийн оюутнуудад нээлттэй зохион байгуулагдана. Үүнд:

- Олимпиадын үйл ажиллагааг даалгаврын гүйцэтгэх ажиллагаа, агуулгаас нь хамааруулан I түвшин, II түвшин гэсэн ангиллаар зохион байгуулна. Үүнд:
 - I түвшин (геодези хөтөлбөрөөр суралцаж байгаа 1, 2-р курсын оюутнууд, геодезийн хичээл судалдаг мэргэжлийн бус ангийн 1-3 курсын оюутнууд)
 - II түвшин (3, 4-р курсын оюутнууд)
- Олимпиадын даалгаврыг багаар гүйцэтгэнэ. Баг нь ахлагч, гишүүд бүхий 6 хүний бүрэлдэхүүнтэй, багийн нэр, уриатай байна. Багийн бүрэлдэхүүнд одоогоор суралцаагүй, жилийн чөлөө авсан, сургуулиас гарсан оюутныг оролцуулахгүй. Оролцуулсан нь батлагдвал багийн нийт оноог хүчингүйд тооцно.
- Олимпиадыг зохион байгуулах комисс, шүүгчдийн зөвлөл тус тусын үүрэгтэйгээр хамтран зохион байгуулна. Үүнд:
 - Олимпиадын бэлтгэл хангах, зохион байгуулах ажлыг ШУТИС-ийн ГУУС-ийн Геодезийн салбараас баталсан “зохион байгуулах комисс” хариуцна.
 - Олимпиадын шалгаруулалтын материал боловсруулах, шалгах, үнэлэх ажлыг “шүүгчдийн зөвлөл” хариуцна.
- Олимпиадын бодлого, даалгавар I түвшин, II түвшинд ялгаатай байна.

I түвшинд гүйцэтгэх даалгавар

- Багийн гишүүдийн онолын мэдлэг шалгах асуулт, хариултын тэмцээн
- Биечлэн гүйцэтгэх даалгавар “Үл хүрэлцэх зай хэмжих”

“ГЕОДЕЗИ 2024” улсын олимпиадын I түвшний даалгавар

/1, 2-р курсын оюутнууд/

№	Даалгавар	Даалгаврын шаардлага, нөхцөл	Үнэлгээ	Хугацаа
I.1	Асуулт хариултын тэмцээн	1 асуулт, 1 бодлого бүхий хувилбар байна. (онолын асуулт, бодлого байна.)	Зөв хариулт бүр 10 оноо, нийт 20	Гүйцэтгэл 20 минут
I.2	Биечлэн гүйцэтгэх даалгавар	Өгөгдсөн 2 цэгийг ашиглан очихгүйгээр “үл хүрэлцэх зай” хэмжих аргаар хэмжилт, боловсруулалт хийн 3 цэгийн хоорондох зай, болон өнцгийг тодорхойлно.	40 оноо	90 минут Илтгэл бэлтгэнэ.
I.3	“Үл хүрэлцэх зай хэмжих”	Хэмжилтийн цэгүүдийн байршлын /бүдүүвч, схем/ геометр дүрсийг гарган, бодолтын томъёог бичин, тайлбар бичиглэл хийнэ.	40 оноо	танилцуулах хугацаа 7-8 минут

- Даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг олимпиад эхлэхэд баг тус бүрд хүлээлгэн өгнө.
- I.1 даалгаврыг шүүгчдийн зөвлөл боловсруулж, битүүмжилсэн байна. Даалгаврын битүүмжлэлийг нийт багуудад шалгуулж, түүний дараа нээнэ.
- I.2 даалгавар буюу багийн гишүүдийн биечлэн гүйцэтгэх ажилд хэмжилт, боловсруулалт хийнэ. Хэмжилтийг теодолитоор гүйцэтгэнэ. Тухайн баг хэмжилтэд ашиглах цэгийг сугалаагаар сонгоно. Өгөгдсөн цэгүүдийн хоорондох өнцөг, зай хэмжинэ. Сэлгэцийн тэгшитгэн бодолт хийнэ. Хэмжилтийн цэгүүдийн бүдүүвчийг ватум цаасан дээр зурж, бодолтын бичиглэл, тайлбарыг бүрэн хийнэ. Тайлбарыг 7-8 минутын хугацаанд танилцуулна.

II түвшинд гүйцэтгэх даалгавар

1. Багийн гишүүдийн онолын мэдлэг шалгах асуулт, хариултын тэмцээн
2. Биечлэн гүйцэтгэх даалгавар “Агаарын зураглалын аргаар байр зүйн зураг зохиох”

“ГЕОДЕЗИ 2024” улсын олимпиадын II түвшний даалгавар /3, 4-р курсын оюутнууд/

№	Даалгаврууд	Даалгаврын шаардлага, нөхцөл	Үнэлгээ	Хугацаа
II.1	Асуулт хариултын тэмцээн	1 асуулт, 1 бодлого бүхий хувилбар байна. (онолын асуулт, бодлого байна.)	Зөв хариулт бүр 10 оноо, нийт 20	Гүйцэтгэл 20 минут
II.2	Биечлэн гүйцэтгэх даалгавар “Агаарын зураглалын аргаар байр зүйн зураг зохиох”	Аэротриангуляцийн бодолт хийх, (бодолтыг тайлбарлах)	20 оноо	Хугацаа 240 минут. Илтгэл бэлтгэж танилцуулна. Танилцуулах хугацаа 7-8 минут
		Гадаргуугийн тоон загвар үүсгэх, засварлах	20 оноо	
		Ортофото үүсгэнэ.	20 оноо	
		1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохионо.	20 оноо	

1. Даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай боловсруулалтын программ хангамж суулгасан компьютер, төхөөрөмжөө баг тус бүр бэлтгэж ирнэ.
2. II.1 даалгаврыг шүүгчдийн зөвлөл боловсруулж, битүүмжилсэн байна. Даалгаврын битүүмжлэлийг нийт багуудад шалгуулж, түүний дараа нээнэ.
3. II.2 Багийн гишүүд “Агаарын зураглалын аргаар байр зүйн зураг зохиох” биечлэн гүйцэтгэх даалгавар гүйцэтгэнэ. Даалгаварт агаарын зургийн талбайг шүүгчдээс өгнө. Тайлбарыг 7-8 минутын хугацаанд танилцуулна. Даалгаврын битүүмжлэлийг нийт багуудад шалгуулж, түүний дараа нээнэ.

ТАВ. ОЛИМПИАДЫН ШАЛГАРУУЛАЛТ БА ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

1. Шалгаруулалтыг шударга, ил тод явуулах үүднээс хамтран зохион байгуулж буй байгууллагын төлөөлөл бүхий шүүгчдийн зөвлөл шүүнэ.
2. Шүүгч тус бүр даалгавар тус бүрд үнэлгээ өгч, тухайн багийн нийт оноог гаргана. Тухайн багт өгсөн шүүгчдийн онооны нийлбэрээр “Багийн нийлбэр дүн”-г гаргана.
3. Олимпиадын даалгаврын дагуу “Багийн нийлбэр дүн”-гээр жагсаалт гаргаж, хамгийн өндөр оноотой багаас буурах дарааллаар шагналт байрыг шалгаруулна. I, II түвшин тус бүрд 1-3 байрыг шалгаруулж, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар урамшуулна.

ХОЛБОО БАРИХ УТАС, ХАЯГ

ШУТИС-ийн хичээлийн I байр, Геодезийн салбар 1-227 тоот

УТАС: (976)-11-452485

ФАКС: (976)-11-452485

П.Эрдэнэчимэг

88056133

erdenechimeg.geo@must.deu.mn

Б.Гантулга

99141733

blgnsrn@must.edu.mn

Д. Дөлгөөн

89009474

dulguun.d@must.edu.mn

“ГЕОДЕЗИ 2024” УЛСЫН ОЛИМПИАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- 08:30-09:00 Багуудын бүртгэл, олимпиадад оролцох дарааллыг сугалах
- 09:00-09:20 Даалгавар гүйцэтгэх зааварчилгаа танилцуулах (хөдөлмөрийн аюулгүй байдал, техник хэрэгсэл, технологийн дарааллын талаарх)
- 09:20-13:00 I, II түвшний Багийн гишүүдийн онолын мэдлэг шалгах асуулт, хариултын тэмцээн (багууд нэгэн зэрэг гүйцэтгээд шүүгчдэд хураалгана)
- 09:30-аас I, II түвшний Багуудын биечлэн гүйцэтгэх даалгавар эхэлнэ.
- 11:30-12:00 Нээлтийн үйл ажиллагаа: ШУТИС, ГУУС-ийн захирал К.Хавалболот (Дурсгалын зураг татуулах)
- 12.00-13.00 Завсарлага
- 13:00-14:30 I түвшний Багуудын биечлэн гүйцэтгэсэн даалгаврын танилцуулга
- 14:40-15:40 II түвшний Багуудын биечлэн гүйцэтгэсэн даалгаврын танилцуулга
- 16:00-17:00 Багуудын дүнг танилцуулж, шагнал гардуулна.

Жич:

1. Багийн ахлагч нараар дугаар бүхий сугалаа сугалуулж даалгавар гүйцэтгэх дарааллыг тогтооно. Багууд сугалсан дугаарын дарааллаар даалгаврыг гүйцэтгэнэ. Үнэлгээний хуудсыг бэлтгэж, шүүгчдийн зөвлөлд өгнө. Багууд хэмжилтэд өөрсдийн сугалсан дугаартай багаж, хэрэгслийг ашиглана.
2. Оролцох багууд мэдүүлгийн хуудсыг загварын дагуу бөглөж, харьяа сургуулийн сургалтын албаар баталгаажуулсан байна. Оролцогчид оюутны үнэмлэхээ авчирна. Багийн мэдүүлгийн хуудсыг Хавсралтаар 5-аар хүргүүлнэ.

“ГЕОДЕЗИ 2024” улсын олимпиадад оролцох багийн мэдүүлэг

..... сургуулийн салбар/тэнхим

Олимпиадад оролцох оюутны нэрс, баг

№	Багийн нэр	Багийн уриа	Багийн гишүүд	Оюутны код	Курс, анги
1					
2					
3					
4					
5					
6					
1					
2					
3					
4					
5					
6					

Олимпиадад оролцох нэр бүхий оюутны нэрсийг баталгаажуулж оюутны үнэмлэхийг хавсаргав.

Удирдагч багш:

Хянасан СА-ны ажилтан:

Зөвшөөрсөн Дэд захирал:

Мэдүүлэг хүлээн авагч: ШУТИС-ийн ГУУС-ийн Геодезийн салбар
 Мэдүүлэг хүлээж авах хугацаа: 2024.04.20
 Мэдүүлэг хүлээн авах байр: Хэвлэмэл хэлбэрээр - ШУТИС-ийн хичээлийн 1-р байрын 1-227 тоот өрөө;
 Цахим хэлбэрээр: blgnsrn@must.edu.mn;
 Холбоо барих утас: 99141733